



ИРГЭДЭД ОЙР ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР УЛСЫН ХЭМЖЭЭНД ГЭМТ ХЭРЭГ БУУРЛАА

Цагдаагийн байгууллагад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 200133 гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч шалгаж шийдвэрлэлээ.




Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 39.06 хувийг 5 хоногт, 60.9 хувийг 6-19 хоногт, 0.04 хувийг 20 түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 94.8 хувийг 14 хоногт, 5,1 хувийг 15-28 хоногт, 0.04 хувийг 29 ба түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

Цагдаагийн байгууллагаас ард иргэдийн аюулгүй амар тайван амьдралын баталгааг хангахын тулд хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэдийн оролцоо, дэвшилтэт техник технологийг ашиглан олон талт ажил, арга хэмжээг авч хэрэгжүүллээ.




Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 1,7 хувиар өссөн байна.



Цагдаагийн байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Олон нийтийн цагдаа” “Урамшилт эргүүл” “Өсвөрийн сэргийлэгч”, “Малчдын бүлэг, холбоо нөхөрлөл”, “Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих журам”, “Оюутан цагдаа”, “Хөршийн хяналт” хөтөлбөр, “Аюулгүй хот” төслийн “Гэмт хэргийн хяналтын цогц систем”, “Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр нийт гэмт хэргийн 31.7 хувийг эзэлж байгаа хулгайлах гэмт хэрэг сүүлийн 5 жилд анх удаа 23 хувиар буурлаа.



ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ



Нийслэлийн дүүргүүдэд ажиллах явган эргүүлийн тоог нэмэгдүүлж, нийт 5700 алба хаагч, 263118 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 342860 зөрчлийг илрүүлжээ.



Зөрчил гаргасан 717991 иргэн, 44 албан тушаалтан, 709 аж ахуйн нэгж, байгууллагад 20,5 тэрбум төгрөгөөр торгох, 13531 иргэнд торгож эрх хасах, 7008 иргэнд баривчлах шийтгэл ногдуулсан.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1705 удаагийн яриа, сэрэмжлүүлгийг давхардсан тоогоор 67456 хүнд хүргэж сурталчлав.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчсөн 792 зөрчлийг илрүүлэн, 575 иргэн, 3 албан тушаалтан, 214 аж ахуйн нэгж, байгууллагыг 79,4 сая төгрөгөөр торгож, 2176 литр архи, 1155 литр пиво хураан авч, 53 байгууллага, аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналаа холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Улсын хэмжээнд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэгт холбогдсон хүний тоо өмнөх оны мөн үеэс 7,3 хувиар буурч, эрүүлжүүлэгдсэн хүний тоо 0,15 хувиар тус тус нэмэгдсэн байна.



Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 21 гэр бүлийн 41 иргэнийг хамгаалалтад авч, “107” тусгай дугаарын утсанд нийт 4787 иргэн хандсаны 937 иргэнд сэтгэл зүйн, 3850 иргэнд бусад хууль эрх зүйн, өөрийн биеэр ирсэн 31 иргэнийг хүлээн авч, зөвлөгөө, мэдээлэл өглөө.

ЖАГСААЛ, ЦУГЛААН



Улсын хэмжээнд нийт 45 удаа зохион байгуулагдсан жагсаал, цуглааны үед 899 алба хаагч 180 цаг хэв журам сахиулж ажилласан.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль, дахин санал хураалтын саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, санал авах байрны хамгаалалтад нийт 6100 алба хаагч 240 цагийн үүрэг гүйцэтгэсэн.



Тулгар төрийн 2226, Их Монгол Улс байгуулагдсаны 811, Ардын хувьсгалын 96 жилийн ой, Үндэсний их баяр наадмын хамгаалалтад нийт 3824 алба хаагч 84 цагийн үүрэг гүйцэтгэв.



Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 24 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг үндэслэн нийт 709 удаагийн тээвэрлэлтийн хамгаалалтад 789 алба хаагч ажилласан.

Цагдаагийн байгууллага улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 41 шүүхийн байрыг 24 цагаар хамгаалан нийт 23110 шүүх хуралдааны үед дэг журам сахиулан ажилласан.



Эрүүгийн 8054

Иргэний 13118

Захиргааны 1938

Гэрч, хохирчийг хамгаалах тухай хуулийн дагуу нийт 11 арга хэмжээний хүрээнд 19 иргэний аюулгүй байдлыг хангаж ажиллав.

Гэрч-3

Хохирогч-3

Шүүгч-3

Проркурор-2

Иргэн хамаарал бүхий
этгээд-8



Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 183 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, 226396 зөрчил илрүүлэн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэлээ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослын улмаас:

НАС БАРСАН ХҮН



2016 оны
хагас жил

112

2017 оны
хагас жил

147 ↑ 31,3

ГЭМТСЭН ХҮН



2016 оны
хагас жил

410

2017 оны
хагас жил

443 ↑ 6,9%

Цаашид Цагдаагийн байгууллагаас:

- Цагдаагийн байгууллагын тэргүүлэх чиглэл болсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх
- Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн туслалцаа дэмжлэгт түшиглэн үйл ажиллагаагаа шуурхай хүртээмжтэй явуулах
- Гэмт хэрэгтэй тэмцэх ажилд мэдээллийн техник, технологийн шинэчлэлийг түлхүү ашиглах
- Эрүүгийн болон Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн болон Зөрчлийг хянан шийдвэрлэх тухай хуулиудын хэрэгжилтийг хангах
- Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйг дээшлүүлэхэд анхааран ажиллах болно.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ ХАМТДАА